222

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 23 өдөр Дугаар А/46 Улаанбаатар хот

Коронавирусын халдвар авч,
өвдөөд эдгэрсэн албан хаагчдыг
нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 259 дүгээр тогтоол, ХАГ/01 гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар авч, өвдөөд эдгэрсэн албан хаагчдыг нөхөн сэргээх эмчилгээ, сувилалд хамруулах ажлыг зохион байгуулсугай.

2. Нөхөн сэргээх эмчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлэг, сувилалын газруудад эмчлүүлсэн албан хаагчдын эмчилгээний зардалд 600.000 (Зургаан зуун мянга) хүртэл төгрөг байхаар тооцон төлбөрийг үйл ажиллагааны бус зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Ц.Алтангэрэл)-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны асуудал хариуцсан орлогч дарга (Ш.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА Б. МӨНХБАТ

D:\2021 он\Албан бланк\tushaal.docx

315060000727